



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 341.

Улаанбаатар хот

Р.Будыг ажлаас чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 42 дугаар зүйлийн 42.1, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Будтай байгуулсан контрактын 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Рэнцэн овогтой Буд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын үүрэгт ажлаас 2021 оны 08 дүгээр сарын 16-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг цуцалсугай.

2. Тэтгэвэрт гарах болсонтой нь холбогдуулан Р.Будад 3 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Б.Дуламхандад даалгасугай.

3. Р.Будтай санхүү, эд аж ахуйн холбогдох тооцоог хийж, 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохих журмын дагуу ажил хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001285